

**Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны  
санхүүгийн баримтад хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмж,  
албан шаардлагын хэрэгжилт**

2023.05.25

д/д	Зөвлөмж, алдаа зөрчлийн утга	Нийт алдаа зөрчил		Биелэлт
		Тоо	Дүн	Тайлбар
<b>1. Шалгалтаар өгөгдсөн зөвлөмж</b>				
1	Засгийн газрын 2020 оны 218 тоот тогтоолын дагуу албан хаагчдын улирлын ажлын үр дүнг хагас жилээр дүгнэж хэвших, үр дүнг тооцож хуулийн дагуу урамшуулал олгох	1		Засгийн газрын 2020 оны 218 тоот тогтоолын дагуу албан хаагчдын улирлын ажлын үр дүнг хагас , бүтэн жилээр тогтмол дүгнэж үр дүнг тооцож хуулийн дагуу хагас, бүтэн жилээр батлагдсан төсвийн хүрээнд багтаан урамшуулал олгож зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллна.
2	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна. 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7. Анхан шатны баримт баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, “ Өмчийн бүх хэлбэрийг аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж сар бүр шатахууны тооцоог бодох	1		Цаашид нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон “ Өмчийн бүх хэлбэрийг аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг мөрдөж сар бүр шатахууны тооцоог бодох ажилллаж байна.
3	Монгол улсын Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 тушаал”-ын дагуу албан томилолтыг тооцох олгож байх	1		Албан хаагчид нь суманд томилолтоор ажиллахдаа хоногоор яваагүй өдөртөө ажиллаж ирсэн үед зам хоног хоолны зардлыг батлагдсан төсөвтөө багтаан, хоногоор ажиллаж байгаа тохиолдолд байрны зардалтай батлагдсан төсөвт багтаан хуулийн дагуу олгож байна.
4	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д “Энэ хуулийн 23.8-д заасан журмын дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирлах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэж	1		Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу мэдэгдлийг тухай бүр гаргаж баталгаажуулан, шилэн дансанд байршуулан, нийтэд мэдээлж байна. Одоогоор нийт 9 мэдэгдлийг гарган

	заасны дагуу мэдэгдэл тухай бүр гаргаж баталгаажуулан, шилэн дансанд байршуулан, нийтэд мэдээлж хэвших			шилэн дансанд байршуулаад байна.
<b>2. Албан шаардлага</b>				
1	“Сумын нийгмийн даатгалын байцаагчид шатахууны зардал олгох журам”-ын дагуу байцаагч нарт мөн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд олгосон 2021, 2022 онд нийт 10,038.5 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй.	1	10038,5 мян төг	2021, 2022 оны сумдын шатахуун зарцуулалтын баримтыг байцаагч нар тухай бүр ирүүлж байсныг санхүүгийн баримт болон, няравын тайланд үдээгүй, архивт шилжүүлээгүй няравт хадгалагдсан байсныг баримтын бүрдлийг хангаж няравын тайланд үдэж архивт шилжүүлж албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажилласан. Мөн байгууллагын үйл ажиллагаанд олгосон шатахууны 2022 оны шатахууны тооцоог нягтлан бодогч тухай бүр компьютер дээр тооцдог боловч санхүүгийн баримтад хэвлэж хийгээгүй байсныг хэвлэж хийсэн. Энэ он гарсаар олгосон шатахууны тооцоог тухай бүр бодож алдаа зөрчлийг таслан зогсоож ажилласан.

СБТ –ийн дарга , ахлах нягтлан бодогч:  
 Үйл ажиллагааны нягтлан бодогч:

/Р.Нэргүй/  
 / Ё.Даариймаа/

